БАТЛАВ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
А.ЭНХМАНЛАЙ

БАТЛАВ
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.ЗОРИГТБАЯР

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН
1:1000-НЫ МАСШТАБТАЙ БАЙР ЗҮЙН ЗУРАГ ЗОХИОХ
АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 12 дүгээр сарын 22 Дугаар 2025 /А29/73

д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажлын үндэслэл	1. Геодези, зураг зүйн тухай хууль; 2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 267-р тогтоол;
2.	Ажлын зорилго	Орхон аймгийн Баян-Өндөр сумын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохионо.
3.	Хамрах хүрээ	Орхон аймгийн Баян-Өндөр сумын төв.
4.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хуанлийн 180 хоног
5.	Гүйцэтгэх ажлын хэмжээ	Орхон аймгийн Баян-Өндөр сум 24900 га талбай
6.	Ажлын иж бүрдэл	**1. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хайгуул судалгаа, суулгалт:** - Ажлын хамрах хүрээний талбайд геодезийн байнгын цэг, тэмдэгтийн судалгааг хийж, устсан болон нөхөн сэргээх, шинээр суулгах цэг, тэмдэгтийн тоо хэмжээ, жагсаалтыг гаргана. - 10-с багагүй геодезийн байнгын цэг, тэмдэгт бэлтгэж суулгах, хувийн хэрэг хөтлөх, геодезийн байнгын цэг тэмдэгтийг төрийн хамгаалалтад хүлээлгэн өгч, мэдээллийг геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим мэдээллийн сангийн загварын дагуу бэлтгэж, хүлээлгэн өгнө. **2. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн газарт суулгах:** - Геодезийн цэг тэмдэгт суулгах газарт тавих үндсэн шаардлага: - Цэгийн хэлбэр хийц болон түүнийг суулгах гүн, гаднах тэмдэглэл нь урт хугацаанд хадгалагдах нөхцөлийг бүрдүүлэх; - Геодезийн цэгийн төв ба репер суулгах газар нь хүрч очих, олох, ашиглахад хялбар, удаан хугацаанд хадгалагдах нөхцлийг бүрдүүлсэн, хэмжилтийг аль ч улиралд, ямар ч тохиолдолд тасралтгүй хийх боломжтой байх; - Шинээр суулгах цэг тэмдэгтийн төвийн байрлалыг тогтоохдоо тухайн цэгийг ашиглан аль болох том хэмжээний талбайн зураглал хийх боломжтой нөхцөлд цаашид устаж үгүй болох эрсдлээс хамгаалж, цэгийн төвийг газрын гадаргаас дээш цухуйлгахгүйгээр газрын гадаргатай ижил түвшинд суулгах; Геодезийн цэг тэмдэгтийн удаан хадгалагдах боломжийг хангахын тулд доорх газарт суулгахыг хориглоно. Үүнд: - Уулын хажуу, өмнөд бэл газар; - Өвөл нь цас их шуурч, цасан хунгар тогтдог газар

		- Зундаа чийг их хуримтлуулдаг, өвөл нь цас их унадаг нам газар; - Хөлдөөсний ан цавтай, үер их буудаг газар; - Хот суурин газарт барилга байгууламж, зам талбай барихаар төлөвлөсөн газар, усан цахилгаан станц, уулын ажил өрнөх, усжуулалтын үйл ажиллагаа явагддаг, нуранги, мөсжилт явагдах төлөвтэй намаг шалбааг хунгар үүсэх зэрэг байгалийн тогтоц, түүний өөрчлөлтийн хүчин зүйлд автагдах эрсдэл бүхий газар; - Радио долгион (радио станц, радар, радио долгион дамжуулах антен г.м) дамжуулах эх үүсвэрийн ойролцоо, цахилгаан дамжуулах шугамын орчинд; - Газрын тос, шатдаг хий, гүний ус олборлолтын цамхгийн дэргэд; - Инженер геологийн хүнд нөхцөлтэй газарт (хөрсний гулсалт, нуранги, хөрсний усны өндөр түвшинтэй, овоолт, суулт); **3. Геодезийн сүлжээ байгуулах:** - Баян-Өндөр сумын геодезийн сүлжээ байгуулах (солбицлын дэд тогтолцоонд); - Улсын геодезийн сүлжээ байгуулах (солбицлын нэгдсэн тогтолцоонд); - Өмнө байгуулсан өндрийн II ангийн сүлжээний үр дүнг ашиглах - Сүлжээг GNSS-ийн аргаар болон өнцөг зайн хэмжилтийн багажаар харьцуулсан хэмжилт хийх. - Солбицлын нэгдсэн тогтолцоо, дэд тогтолцоо хоорондын хөрвүүлэлтийн параметрыг тодорхойлж, газар дээр хэмжилт хийж харьцуулан шалгаж харилцан хамаарлын утгыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргаар батлуулах; **4. Геодезийн сүлжээний хэмжилт, тэгшитгэн бодолт:** - Нөхөн сэргээсэн болон шинээр суулгасан цэгүүдэд GNSS-ийн 8-12 цагийн статик хэмжилт хийнэ. - GNSS-ийн сүлжээний цэг тэмдэгтийн статик хэмжилтийн ажлыг гүйцэтгэхдээ ажлын талбайд ойр байрлах өндрийн сүлжээний II ангийн 1-2 цэг тэмдэгтийг оролцуулан хийнэ. - GNSS-ийн сүлжээний статик хэмжилтийн өгөгдлийг ITRF2020 солбицлын тогтолцоонд (2015.01.01) тэгшитгэн бодож, цэгүүдийн каталоги боловсруулна. **5. Агаар мандлаас газрын зураг авах:** - Агаар мандлаас онгоцоор эсвэл дроноор газрын зураг авах; - Агаар мандлаас газрын зураг авах нарийвчлал GSD 5 см хүртэл байна. - Дижитал твин (Digital twin) үзэл баримтлалд нийцсэн хотын гурван хэмжээст (3D) тоон загварыг агаарын зурагт суурилан боловсруулна. Гурав ба дөрвөн хэмжээст газрын кадастрын нэгдсэн сан бүрдүүлэхэд ашиглах боломж бүрдэнэ. **6. Газар доорх шугам сүлжээг зураглах:** - Газар дээрх болон газар доорх инженерийн шугам сүлжээ, тэдгээрийн ашиглалтын байдлыг тодорхойлж, холбогдох барилга байгууламжийн хамт нэгтгэн гурван хэмжээст (3D) тоон загвараар боловсруулах. - Газар доорх инженерийн шугам сүлжээний шугамын судалгаа, эргэлтийн геодезийн хэмжилт хийж солбицол, өндрийг тодорхойлох. - Газар доорх инженерийн шугам сүлжээний 1:500-ны масштабтай дэвсгэр зураг зохиох. **7. Суурин боловсруулалт хийх:** - Геодезийн сүлжээний өгөгдөл тэгшитгэн бодолт хийх;

		- Цэгүүдийн хувийн хэрэг, хүлээлгэн өгсөн актын жагсаалт, байрлалын схем зураг гаргах; - Хөрвүүлэлтийн параметр бодсон тайлан, шалгалт, туршилт, хэмжилтийн өгөгдөл боловсруулах; - Аэротриангуляцийн тэгшитгэн бодолт хийх; - Газрын гадаргуугийн тоон загвар үүсгэх; - Ортофото зураг үүсгэх; - 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зураг зохиох; - (3D) хотын загварын мэдээллийн сан үүсгэх; - Дотоодын хяналт шалгалт хийх. **8. 3D хотын загвар, мэдээллийн сан боловсруулах** - Сонгон шалгаруулалтад шалгарсан компани гурван хэмжээст (3D) хотын загвар, мэдээллийн сан боловсруулах ажлын төлөвлөгөөг батлуулна. - Газар нутгийн цахим фото-текстурчилсан гурван хэмжээст (3D) загвар боловсруулах - Гурван хэмжээст (3D) загварыг бий болгоход ашигласан болон холбогдох програм хангамж болон түүнийг суулгах ашиглахад хамаарах онцгой бус ашиглах эрх олгох - Гадаргуугийн зүйвэр зургийн (mosaic) орон зайн шийдэл нь 5см ба түүнээс өндөр нарийвчлалтай байна. - Байр зүйн зургийн элементүүдийн нягтрал нь бодит хотын тархалтыг илэрхийлэх ёстой бөгөөд хэт гоёлын шинжтэй байж болохгүй. - Хотын загвар нь бодит цагийн болон интерактив хэрэглээнд тохирсон байна. - 3D формат: FBX, OBJ, GLTF/GLB, USD - Гурван хэмжээст (3D) хотын загварт газрын өндөр, налуу, хотын элементүүд (зам, гүүр, барилга, ус, шугам сүлжээ) хоорондоо зөрчилгүй, бодит байршлаараа зөв холбогдсон байна. **9. Байр зүйн зураглалын ажлын тайлан бичих.** **10.Геодези, байр зүйн ажлын үр дүнг улсын нэгдсэн санд хүлээлгэн өгөх.** **11.Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системд оруулах.** **12.Байр зүйн зураг, агаарын зураг, өндрийн тоон загвар, ортофото зураг, орон зайн өгөгдлийн сангийн өгөгдөл, мэдээллийг боловсруулах, хадгалах зориулалттай тоног төхөөрөмж худалдан авах** - Процессор (CPU) - /Intel Core Ultra 9 285 vPro, 24 цөм, 5.6 GHz хүртэл хурдтай дүйцэхүйц, түүнээс дээш/ - Санах ой (Memory) - /64 GB DDR5, 5600 MT/s, non-ECC загвар нь (4 × 16 GB)-тай дүйцэхүйц, түүнээс дээш / - Хадгалах (Storage) - /1TB, 4TB NVMe, M.2, SSD (TLC)-2ш/ - График (Graphics) - /NVIDIA GeForce RTX 5080 GPU, RAM-32GB/ -Сүлжээ ба Холболт - /Wi-Fi 6E (IEEE 802.11ax), Bluetooth болон Gigabit Ethernet дэмждэг/ - Дэлгэц - /Dell U2724D UltraSharp 27-30 inch 120Hz 2K/
7.	Ажлын үр дүн	- Геодезийн сүлжээний хэмжилт, тэгшитгэн бодолт үр дүн; - Хөрвүүлэлтийн параметр; - Цэгүүдийн хувийн хэрэг, солбицлын жагсаалт - Газрын гадаргуугийн тоон загвар; - Агаарын ортофото зураг; - 1:1000-ны масштабтай тоон байр зүйн зураг; - Газар доорх инженерийн шугам сүлжээний 1:500-ны масштабтай дэвсгэр зураг; - Бүрэн 3D хотын загвар, мэдээллийн сан;

		- Дээрх өгөгдөл мэдээлэл, зургийг Геодези, зураг зүйн удирдлагын нэгдсэн системд оруулсан байна. - Бүх орон зайн өгөгдөл, Гурван хэмжээст (3D) загвар, инженерийн шугам сүлжээний мэдээллийг Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн стандарт, мета өгөгдөл, OGC үйлчилгээ, геопорталын интеграцын шаардлагад бүрэн нийцүүлж боловсруулах, улсын нэгдсэн санд шууд ашиглагдах өгөгдлийн бүтэцтэй хүлээлгэн өгөх.
8.	Техникийн шаардлага	● **Байрлал, өндрийн үндэслэл, тусгаг** - Геодезийн солбицлын нэгдсэн тогтолцоо ITRF2020 (UTM тусгаг); - Геодезийн солбицлын дэд тогтолцоо (1.0 масштабын итгэлцүүр); - Балтын тэнгисийн өндрийн тогтолцоо. ● **Байр зүйн тоон зураг** - 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг зохиохдоо 0.5м үеийн өндөртэй байх; - Газар доорх шугам сүлжээний 1:500-ны масштабтай дэвсгэр зургийг зохиохдоо газар доорх шугам сүлжээний агуулгатай байх; - Зураглалын ажлын үед дотоодын хяналт, шалгалтыг ажлын үе шат бүрт хийх. ● **Ашиглах норм, дүрэм, стандарт** - Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ БД 81-103-21 барилгын дүрэм; - Геодезийн байнгын цэг,тэмдэгт байгуулах ажил БД 11-104-19 барилгын дүрэм; - Навигацийн хиймэл дагуул GNSS-ын технологиор Монгол Улсын геодезийн сүлжээ байгуулах дүрэм БНбД 11-13-22 барилгын норм, дүрэм; - Монгол Улсын өндрийн I ба II ангийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм БНбД 11-09-16 барилгын норм, дүрэм; - Өндрийн I ба II ангийн сүлжээний тэгшитгэн бодолтын ажил БД 11-107-16 барилгын дүрэм; - "Байр зүйн болон дэвсгэр зураглалын ажил" БНбД 11-106-25 дүрэм; - Агаар, сансрын зураглалын ажил БНбД 11-14-23 барилгын норм, дүрэм; - Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил (БД 11-105-19) барилгын дүрэм; - Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөрагаарын зураглал ба газрын зураг гүйцэтгэх ажил (БД 11-125-21) - Геодези, зураг зүйн үйлдвэрлэлд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм БНбД 11-12-22 барилгын норм, дүрэм; - ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны А/405 дугаар тушаал (Геоидын өндрийн загвар батлах тухай); - Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдгийн стандарт MNS 6702:2017 (Масштаб: 1:500, 1:1 000, 1:2 000,1:5 000); - Газар зүйн мэдээлэл. Байр зүйн зургийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт стандарт MNS 6925-2:2021; - Газар зүйн мэдээлэл. Дэд бүтцийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт стандарт MNS 6925-7:2021; - "Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх" журам; - ISO 14739-1:2014 - ISO 19650-1:2018, ISO 19650-2:2018, ISO 19650-3:2018 - MNS 5774:2007 Газарзүйн мэдээлэл-Мета өгөгдөл ● **Багаж, тоног төхөөрөмж, програм хангамж**

		- Электрон тахеометр 1 секунд болон түүнээс өндөр нарийвчлалтай байх; - Агаар мандлаас газрын зураг авах төхөөрөмж 50мега пикселээс өндөр; - ГЗБГЗЗЕГ-ын багаж баталгаажуулалтын лабораторид баталгаажилт хийгдсэн гэрчилгээтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн буюу IGS-ийн баталгаажуулалт хийгдсэн антен бүхий өндөр нарийвчлалын GNSS-ийн 2 долгионы хэмжилтийн багаж хамгийн багадаа 4 ширхэг түүнээс дээш (3 mm + 0.1 ppm RMS; 5 mm + 0.5 ppm RMS болон түүнээс өндөр нарийвчлалтай байх) - Газар доорх шугам сүлжээ илрүүлэгч багаж. ● **Боловсруулалтын програм, хангамж** - Агаарын зураглал боловсруулах програм; - GNSS-ийн өгөгдөл боловсруулах програм; - Өндрийн сүлжээ өгөгдөл боловсруулах програм; - Байр зүйн зураглалын програм хангамж; - 3D загварчлал боловсруулах програм хангамж;
9.	Хяналт, шалгалт	Ажлын гүйцэтгэлд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хяналт тавина. Ажлын гүйцэтгэлийг шалгаж хүлээн авахад төсөвт өртгийн дүнгээс 6 хувиар тооцож ГЗБГЗЗЕГ-аас зохион байгуулах хяналт шалгалтын ажилд зарцуулна.
10.	Архив, мэдээллийн төвд хүлээлгэн өгөх материал	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны А/194 тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журам"-ын дагуу доорх баримт бичиг, тоон мэдээллийг хүлээлгэн өгнө. Үүнд: **- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан хөмрөгт:** 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан (тоон болон хэвлэмэл байдлаар) - 2%; 2. Геодезийн сүлжээний мэдээлэл, шинээр суулгасан геодезийн байнгын цэг тэмдэгт тус бүр дээр хувийн хэрэг бүрдүүлж төрийн хамгаалалтад хүлээлцсэн акт (хэвлэмэл байдлаар) - 1%; 3. Сүлжээний цэг тэмдэгтийн тэгшитгэн бодолтын тайлан (хэвлэмэл байдлаар) - 1%, хэмжилтийн Rinex өгөгдөл (CD) - 1%; 4. Цэгийн солбицол өндрийн жагсаалт /тоон болон хэвлэмэл байдлаар /- 2% 5. Хөрвүүлэлтийн параметр, гадаргуугийн тоон загвар, ортофото зураг (CD, DVD) дээр бичих - 2%; 6. 1:500-ны масштабтай газар доорх инженерийн шугам сүлжээний зураг - 1%; 7. 1:1000-ны масштабтай байр зүйн зураг - 1%; 8. Бүрэн 3D хотын загвар, мэдээллийн сан, эх файл, мета өгөгдөл, давхаргын тайлбар, техникийн баримт бичиг - 1%; 9. Геодези, зураг зүйн удирдлагын нэгдсэн системд оруулсан мэдээлэл - 1%; - Ажлыг хэрхэн гүйцэтгэх, солбицлын дэд тогтолцоог үүсгэх, харилцан хамаарлын баримт бичиг үйлдэх, параметр бодох, үйлдвэрлэлд хэрхэн нэвтрүүлэх талаар аргачлал боловсруулах, төслийг зөвлөх эсвэл мэргэшсэн инженерийн тамга, гарын үсгээр баталгаажуулсан байна. **- Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт:** 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан (тоон болон хэвлэмэл байдлаар) - 2%; 2. Геодезийн сүлжээ, цэгийн мэдээлэл, шинээр суулгасан геодезийн байнгын цэг тэмдэгт тус бүр дээр хувийн хэрэг

		бүрдүүлж төрийн хамгаалалтад хүлээлцсэн акт (хэвлэмэл байдлаар) - 1%; 3. Хөрвүүлэлтийн параметр, гадаргуугийн тоон загвар, ортофото зураг (CD, DVD) дээр бичих - 2%; 4. 1:1000-ны масштабтай байр зүйн зураг - 1%; 5. 1:500-ны масштабтай газар доорх инженерийн шугам сүлжээний зураг - 1%; 6. Бүрэн 3D хотын загвар, мэдээллийн сан, техникийн баримт бичиг - 1%; **- Сумын Засаг даргын тамгын газарт:** 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан (тоон болон хэвлэмэл байдлаар (CD, DVD) дээр бичих)- 1%;
11.	Захиалагч байгууллага	Орхон аймгийн Засаг даргын тамгын газар, Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
12.	Гүйцэтгэгч байгууллага	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд. Үндсэн ажилтнаар геодезийн хэмжилт, зураглалын зөвлөх эсвэл мэргэшсэн инженер 1, агаарын зураглалын зөвлөх инженер 1, геодезийн инженер 2 байна.
13.	Хөрөнгийн хэмжээ, санхүүгийн эх үүсгэвэр	Орон нутгийн төсөв 3 050 000 000 төгрөг.
14.	Онцгой нөхцөл	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэж болох ба үүнийг гэрээний тусгай нөхцөлөөр тодорхойлно.

ХЯНАСАН:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Ж.ГАЛ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Д.МӨНХЦЭЦЭГ

ЗӨВШӨӨРСӨН:

ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Р.ГАЛБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Б.АМАРЗАЯА

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — В.ОТГОНБАЯР

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Д.УНДАРМАА

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Л.ЗОЛЗАЯА

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ч.ГҮНДЭГМАА

ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Г.БОЛДБААТАР

ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ХОСБАЯР